

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/67/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2021
ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	12
3.1 Ерөнхий зүйл.....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Материаллаг байдал	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	18
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
4. Аудитын илрүүлэлт.....	19
4.1 Залруулсан алдаа	19
4.2 Төлбөрийн акт.....	19
4.3 Албан шаардлага	20
4.4 Зөвлөмж.....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий Аудитор
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
НХМ	Нэг хэвийн маягт
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ОБГ	Онцгой байдлын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/184
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ

D 2022/2022 оны АЛБАН БИЧИГ
19020557

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
			/Төгрөгөөр/
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	48,256,130.14	86,622,451.14
33	АВЛАГА	7,000,000.00	7,000,000.00
335	Бусад авлага	7,000,000.00	7,000,000.00
3351	Байгууллагаас авах авлага	7,000,000.00	7,000,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	41,256,130.14	79,622,451.14
354	Хангамжийн материал	41,256,130.14	64,622,451.14
35410	Бичиг хэргийн материал	177,100.00	165,000.00
35420	Аж ахуйн материал	28,666,470.14	30,054,691.14
35430	Сэлбэг хэрэгсэл	3,399,500.00	6,429,800.00
35470	Бусад хангамжийн материал	9,013,060.00	27,972,960.00
35600	Мал амьтад	00.00	15,000,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	700,322,684.57	788,110,231.87
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	700,322,684.57	788,110,231.87
392	Биет хөрөнгө	699,295,684.57	787,158,231.87
39201	Барилга, байгууламж, орон сууц	647,374,318.07	724,343,017.07
39202	Хуримтлагдсан элэгдэл	-250,583,397.13	-284,429,789.41
39203	Авто-тээврийн хэрэгсэл	198,854,151.00	198,854,151.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-154,455,912.80	-174,217,939.40
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	120,871,128.19	123,262,516.17
39206	Хуримтлагдсан элэгдэл	-77,367,890.06	-82,771,690.60
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,617,513.00	38,497,685.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,116,780.41	-23,603,209.95
39209	Зам, гүүрийн байгууламж	198,667,540.00	198,667,540.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-80,326,522.08	-94,004,347.58
39214	Бусад үндсэн хөрөнгө	101,857,182.00	198,567,182.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-23,095,645.21	-36,006,882.43
393	Биет бус хөрөнгө	1,027,000.00	952,000.00
39301	Програм хангамж	2,780,000.00	2,780,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,105,000.00	-2,180,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	2,662,000.00	2,662,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-2,310,000.00	-2,310,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	748,578,814.71	874,732,683.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	748,578,814.71	874,732,683.01
51	Засгийн газрын хувь оролцоо	748,578,814.71	874,732,683.01
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	575,302,155.68	575,302,155.68
51101	Өмч: - төрийн	575,302,155.68	575,302,155.68
512	Хуримтлагдсан үр дүн	-137,733,929.00	-11,580,060.70
51210	Өмнөх үеийн үр дүн	-137,733,929.00	-137,733,929.00
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	126,153,868.30
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,010,588.03	311,010,588.03
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	748,578,814.71	874,732,683.01

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	/Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	540,022,059.90	603,556,617.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	127,254,768.00	165,703,199.00
120	Нийтлэг татварын бус орлого	127,254,768.00	165,703,199.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	100,845,718.00	153,043,699.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	116,672,118.00	153,043,699.00
120009	Бусад орлого	10,582,650.00	12,659,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,767,291.90	437,853,418.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,702,691.90	118,633,218.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,702,691.90	118,633,218.58
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	377,064,600.00	319,220,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	377,064,600.00	319,220,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	559,039,022.81	474,739,582.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	540,002,922.81	474,739,582.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	520,681,537.19	463,662,939.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,855,923.38	197,098,877.29
210101	Үндсэн цалин	141,587,481.95	136,689,477.29
210102	Нэмэгдэл	31,190,041.43	32,331,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,078,400.00	28,078,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,829,569.01	27,790,400.00
210201	Тэтгэврийн даатгал	19,796,914.01	19,658,341.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,008,164.00	1,956,359.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,606,530.00	1,646,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	401,633.00	411,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,016,328.00	4,117,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,961,831.00	41,095,154.00
210301	Гэрэл, цахилгаан	10,458,990.00	12,671,930.00
210302	Түлш, халаалт	30,332,891.00	28,380,624.00
210303	Цэвэр, бохир ус	169,950.00	42,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,750,800.00	17,155,600.00
210401	Бичиг хэрэг	3,300,700.00	2,402,200.00
210402	Тээвэр, шатахуун	20,262,100.00	13,554,400.00
210403	Шуудан, холбоо, интэрнэтийн төлбөр	1,188,000.00	1,199,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,003,200.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,003,200.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,857,500.00	5,514,500.00
210702	Догоод албан томилолт	5,857,500.00	5,514,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	45,020,364.93	27,546,152.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	44,064,264.93	26,590,052.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,500.00	298,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,600.00	167,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	58,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,402,348.87	145,962,256.01
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	63,886,997.90	54,003,970.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	104,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	110,515,350.97	91,854,285.38

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,321,385.62	11,076,643.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	00.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох тагаас, санхүүжилт	18,321,385.62	11,076,643.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,321,385.62	11,076,643.66
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	19,036,100.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	19,036,100.00	00.00
221001	Их засвар	13,272,500.00	00.00
222001	Тоног төхөөрөмж	465,000.00	00.00
223001	Бусад хөрөнгө	5,298,600.00	00.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(19,016,962.91)	128,817,034.62
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,560,000.00	2,663,166.32
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	3,560,000.00	2,663,166.32
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,560,000.00)	(2,663,166.32)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(22,576,962.91)	126,153,868.30

2.3 Мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
			/Төгрөгөөр/
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	423,349,941.90	450,512,918.58
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,582,650.00	12,659,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,582,650.00	12,659,500.00
120009	Бусад орлого	10,582,650.00	12,659,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	412,767,291.90	437,853,418.58
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	35,702,691.90	118,633,218.58
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	35,702,691.90	118,633,218.58
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	377,064,600.00	319,220,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	377,064,600.00	319,220,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	368,771,941.90	405,176,618.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	368,771,941.90	405,176,618.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	349,450,556.28	392,599,974.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	200,855,923.38	197,098,877.29
210101	Үндсэн цалин	141,587,481.95	136,689,477.29
210102	Нэмэгдэл	31,190,041.43	32,331,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,078,400.00	28,078,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,790,500.00	27,790,400.00
210201	Тэггэврийн даатгал	19,475,526.64	19,556,200.00
210202	Тэггэмжийн даатгал	2,177,868.46	2,058,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,564,594.56	1,646,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	415,473.72	411,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,157,036.62	4,117,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,961,891.00	41,095,154.00
210301	Гэрэл, цахилгаан	10,459,000.00	12,671,930.00
210302	Түлц, халаалт	30,332,891.00	28,380,624.00
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	42,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,750,800.00	17,156,500.00
210401	Бичиг хэрэг	3,300,700.00	2,402,100.00
210402	Тээвэр, шатахуун	20,262,100.00	13,554,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,500,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,857,500.00	5,514,500.00
210702	Дотоод албан томилолт	5,857,500.00	5,514,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,945,662.00	21,567,944.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,989,562.00	20,611,844.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,500.00	298,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,600.00	167,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	58,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,288,279.90	80,876,599.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,288,279.90	80,772,599.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	104,000.00

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	19,321,385.62	12,576,643.66
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,500,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,500,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	18,321,385.62	11,076,643.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	18,321,385.62	11,076,643.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>54,578,000.00</u>	<u>45,336,300.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	54,578,000.00	45,336,300.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	54,578,000.00	45,336,300.00
2200	Дотоод эх үүсвэрээр	54,578,000.00	45,336,300.00
221001	Их засвар	19,768,000.00	
222001	Тоног төхөөрөмж	1,250,000.00	
223001	Бусад хөрөнгө	5,298,600.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,261,400.00	45,336,300.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-54,578,000.00</u>	<u>-45,336,300.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

						/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-115,156,966.09	00.00	771,155,777.62
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-115,156,966.09	00.00	771,155,777.62
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-22,576,962.91	00.00	-22,576,962.91
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-137,733,929.00	00.00	748,578,814.71
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-137,733,929.00	00.00	748,578,814.71
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-137,733,929.00	00.00	748,578,814.71
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	126,153,868.30	00.00	126,153,868.30
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	575,302,155.68	311,010,588.03	-11,580,060.70	00.00	874,732,683.01

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	33,405,851.90	129,324,744.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	33,405,851.90	129,324,744.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,689,562.00	12,611,844.00	
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,689,562.00	12,611,844.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,716,289.90	115,212,900.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,716,289.90	115,108,900.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	104,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	1,500,000.00	
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,500,000.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,500,000.00	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	33,405,851.90	129,324,744.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	33,405,851.90	118,633,218.58	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	10,691,525.42	

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
		/ төгрөгөөр			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	332,798,600.00	328,244,714.38	338,109,300.00	310,111,530.92
21	УРСГАЛ ЗАРДАЛ	332,798,600.00	328,244,714.38	338,109,300.00	310,111,530.92
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	331,798,600.00	327,244,714.38	338,109,300.00	310,111,530.92
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	206,363,700.00	200,855,923.38	205,854,700.00	197,098,877.29
210101	Үндсэн цалин	145,954,300.00	141,587,481.95	145,445,300.00	136,689,477.29
210102	Нэмэгдэл	32,331,000.00	31,190,041.43	32,331,000.00	32,331,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	28,078,400.00	28,078,400.00	28,078,400.00	28,078,400.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,790,500.00	27,790,500.00	27,790,400.00	27,790,400.00
210201	Тэтгэврийн даатгал	19,556,200.00	19,556,200.00	19,556,200.00	19,556,200.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,058,600.00	2,058,600.00	2,058,500.00	2,058,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,800.00	1,646,800.00	1,646,800.00	1,646,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	411,800.00	411,800.00	411,700.00	411,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,117,100.00	4,117,100.00	4,117,200.00	4,117,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,748,000.00	40,961,891.00	41,448,000.00	41,095,154.00
210301	Гэрэл, цахилгаан	11,244,500.00	10,459,000.00	12,244,500.00	12,671,930.00
210302	Түлш, халаалт	30,333,500.00	30,332,891.00	29,033,500.00	28,380,624.00
210303	Цэвэр, бохир ус	170,000.00	170,000.00	170,000.00	42,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	24,750,800.00	24,750,800.00	17,156,500.00	17,156,500.00
210401	Бичиг хэрэг	3,300,700.00	3,300,700.00	2,402,100.00	2,402,100.00
210402	Тээвэр, шатахуун	20,262,100.00	20,262,100.00	13,554,400.00	13,554,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,188,000.00	1,188,000.00	1,200,000.00	1,200,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,500,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	1,500,000.00	1,500,000.00
2107	Томилголт, зочны зардал	5,857,500.00	5,857,500.00	5,514,500.00	5,514,500.00
210702	Дотоод албан томилолт	5,857,500.00	5,857,500.00	5,514,500.00	5,514,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,256,100.00	9,256,100.00	8,956,100.00	8,956,100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,300,000.00	8,300,000.00	8,000,000.00	8,000,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.00	432,000.00	432,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	298,500.00	298,500.00	298,500.00	298,500.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	167,600.00	167,600.00	167,600.00	167,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	58,000.00	58,000.00	58,000.00	58,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	15,032,000.00	16,772,000.00	29,889,100.00	10,999,999.63
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,032,000.00	16,772,000.00	29,889,100.00	10,999,999.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	00.00	00.00	00.00	00.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	0.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	00.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	00.00	00.00
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	382,064,600.00	377,064,600.00	338,109,300.00	310,111,530.92
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,000,000.00	00.00	00.00	
131001	Улсын төсвөөс санхүүжих	5,000,000.00	00.00	00.00	
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	377,064,600.00	377,064,600.00	319,220,200.00	310,111,530.92
132001	Орон нутгийн төсвөөс	377,064,600.00	377,064,600.00	319,220,200.00	310,111,530.92
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	00.00	00.00	18,889,100.00	00.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	00.00	00.00	18,889,100.00	00.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	23	22	23	22
620001	Удирдах ажилтан	06	06	06	06
620002	Гүйцэтгэх ажилтан	11	10	11	10
620003	Үйлчлэх ажилтан	06	06	06	06

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ний өдрийн 02/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, нийтийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэж орон нутгаа хөгжүүлэх шууд ардчиллын зарчмыг баримталсан шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг хангуулах эрхэм зорилго үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажилласан, Төв аймгийн ТЭЗ-ийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 559,039.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 8,385.6 мянган төгрөгөөр тогтоож, ерөнхий материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,088.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 472,587.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 7,088.8 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 5,316.6 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 1,296.8 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузал сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “ Acolous ” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

Орлого:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 319,220.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 153,043.7 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 131,292.7 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 603,556.6 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 319,220.2 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 131,292.7 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 450,512.9 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд өмнөх оны үлдэгдлээс 20,184.3 мянган төгрөг, “Ногоон сум” аянд иргэд аж ахуйн нэгж байгууллагаас хандив 23,963.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/18 захирамжаар 2020 оны үйл ажиллааны үр дүнгийн шагналд 1,500.0 мянган төгрөг, 518 тоот захирамжаар ковид цар тахлын зардалд 5,000.0 мянган төгрөг, шүлхийн пост ажиллуулахад 5,000.0 мянган төгрөг, А/72 захирамжаар ковид цар тахлын хяналт шалгалтад 1,000.0 мянган төгрөг, А/128 захирамжаар биотехникийн зардалд 500.0 мянган төгрөг, А/353 захирамжаар самбар сүүдрэвч байршуулахад 2,500.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс хагас жилийн мал тооллогын зардалд 583.2 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Батжаргал ариутгал халдваргүйтлийн зардалд 500.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас сумын хамтарсан багт 300.0 мянган төгрөг, Статистикийн хэлтсээс статистик хариуцсан ажилтанд 104.0 мянган төгрөг, цахим тендерийн хураамж 175.0 мянган төгрөг, тендерт шалгарсан 2 ХХК-д шилжүүлэх гудамжны гэрэлтүүлэг, камержуулалт хийх ажлын санхүүжилт 25,895.9 мянган төгрөг, аймгийн засаг даргын А/773 захирамжаар сумын ЗДТГ-ын шатахууны өрийг барагдуулах 9,528.6 мянган төгрөг, иргэдэд худалдсан өвс тэжээлийн үнэ 12,659.5 мянган төгрөг, бусад орлого 3,010.1 мянган төгрөг, нийт 131,292.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэн байна.

Зардал:

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны зардлыг 474,739.6 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар нийт мөнгөн зарлагыг 405,176.6 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141155001 тоот дансанд 329,220.2 мянган төгрөгийн орлого, 329,220.2 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100141155408 тоот дансанд 131,292.7 мянган төгрөгийн орлого, 131,292.7 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 1,316,683.8 мянган төгрөг, тайлант онд улс орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн 76,968.7 мянган төгрөгийн ЗДТГ-ын барилгын дээвэр, 60,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн, нийт 136,968.7 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор бүртгэж, 4 байгууллагаас 45,336.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан байна.

ЗДТГ-ын хоёрдугаар байрны цахилгаан зуух шатсан тул, 11,354.7 мянган төгрөгийн дансны үнэтэй, 2,663.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цахилгаан зуухны 21 нэр төрлийн тоног төхөөрөмжийг сумын ИТХ-ын тогтоолоор шийдвэрлэн акталж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 1,487,634.1 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 41,256.1 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 116,902.0 мянган төгрөг, ОБГ болон ОНХС-аас үнэ төлбөргүй шилжүүлэн авсан бусад хангамжийн материал 1,075.0 мянган төгрөг, мат амьтан 15,000.0 мянган төгрөг, нийт 132,977.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд зарцуулсан 94,610.0 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 79,622.5 мянган төгрөг байна.

Авлага, өглөгийн талаар:

Тайлант жилийн авлагын дансны эхний үлдэгдэл 7,000.0 мянган төгрөг, авлага нэмэгдсэн, хасагдсан гүйлгээгүй, эцсийн үлдэгдэл 7,000.0 мянган төгрөг байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 0 төгрөг, нэмэгдсэн 481,006.9 мянган төгрөг, хасагдсан 481,006.9 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 12 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

Санхүүгийн байдлын тайлангийн талаар:

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 79,622.5 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 788,110.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/мянган төгрөг/	
		Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	7,000.0	7,000.0	0
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	41,256.1	79,622.5	38,366.4
Үндсэн хөрөнгө	700,322.7	788,110.2	87,787.5
Нийт хөрөнгө	748,578.8	874,732.7	126,153.9
Өр төлбөр	0	0	0

Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	748,578.8	874,732.7	126,153.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	748,578.8	874,732.7	126,153.9

Авлагын дансны үлдэгдэл өөрчлөлтгүй 7,000.0 мянган төгрөгийг барагдуулахаар цагдаагийн байгууллагад холбогдох баримт материалыг бүрдүүлэн хүргүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 79,622.5 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 38,366.4 мянган төгрөгөөр өссөн нь мал амьтад дансанд ОНХС-аас барга үүлдрийн 30 хуц худалдан авсан, өвөлжилтийн бэлтгэлд 27,973.0 мянган төгрөгийн өвс тэжээлийн нөөц бусад хангамжийн материалд үлдэгдэлтэй байгаа нь нөлөөлж байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 788,110.2 мянган төгрөг болж 87,787.5 мянган төгрөгөөр өсөхөд улс, орон нутгийн төсвөөс санхүүжигдсэн 136,968.7 мянган төгрөгийн ЗДТГ-ын дээвэр, цэцэрлэгт хүрээлэн, нийлүүлэгч 4 байгууллагаас 45,336.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг худалдан авсан нь нөлөөлж байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 91,854.3 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 8,691.6 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 874,732.7 мянган төгрөг болж, 126,153.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 359,407.4 мянган төгрөгөөр төлөвлөн, нийт урсгал зардалд 359,407.4 мянган төгрөг төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 21,298.1 мянган төгрөгөөр бууруулан орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал зардлын эх үүсвэрийг 319,220.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг 18,889.1 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 319,220.2 мянган төгрөгөөр, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг 18,889.1 мянган төгрөгөөр, нийт 338,109.3 мянган төгрөгөөр сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор баталсан байна.

Төсвийн явцад тодотгол хийгдээгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 319,220.2 мянган төгрөгийн урсгал санхүүжилтийг бүрэн авч, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 9,108.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 310,111.5 мянган төгрөг буюу 91.7 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

ЗДТГ-ын хоёрдугаар байрны цахилгаан зуух шатсан тул, 11,354.7 мянган төгрөгийн дансны үнэтэй, 2,663.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртөгтэй цахилгаан зуухны 21 нэр төрлийн тоног төхөөрөмжийг сумын ИТХ-ын тогтоолоор шийдвэрлэн акталсан байна.

Элэгдлээрээ өртөгөө бүрэн нөхөөгүй 2,663.2 мянган төгрөгийн үлдэгдэл өртгийг санхүүгийн үр дүнгийн тайланд үйл ажиллагааны бус зардлаар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд улс, орон нутгийн төсвөөс санхүүжигдсэн 136,968.7 мянган төгрөгийн ЗДТГ-ын дээвэр, цэцэрлэгт хүрээлэнгийн хүлээж авах материал нь тайлан гарсны дараа ирсэн учир тайланд залруулга хийж, үндсэн хөрөнгөд орлого авсан бөгөөд эдгээр хөрөнгүүд тооллогын бүртгэлд тусгагдаагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын ЗДТГ-ын Ковид-19 цар тахлын үед 2020 оны шилжих үлдэгдлээр тээвэр шатахууны зардалд 8,878.0 мянган төгрөг, эм бэлдмэл, витамин, хамгаалах хувцасны зардалд 3,493.0 мянган төгрөг, сумын онцгой комиссын гишүүдийн хоол хүнсний зардал 255.0 мянган төгрөгийн зардлыг шийдвэрлэж зарцуулсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор 2 бүлэг 5 зорилт 100 хэрэгжүүлэх арга хэмжээтэй Дэлгэрхаан сум үүсгэн байгуулагдсаны 100 жилийн ойг угтан хэрэгжүүлэх 100 бүтээлч ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс 15,000.0 мянган төгрөгөөр 30 хуц мал амьтад дансанд орлого авсан боловч, гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд 7,000.0 мянган төгрөгөөр барга үүлдрийн 34 хуц, 3 ухна авчирч малчдад гэрээгээр эзэмшүүлэн ажиллаж байна гэж тайлагнасан байна. Энэ талаар Тамгын газрын дарга А.Цэдэн-Ишээс тодруулахад: “ОНХС-аас 7,000.0 мянган төгрөгөөр 12 хуцыг худалдаж авсан, 22 хурган хуц 3 ухна ишиг малчдаас сумынхаа 100 жилийн ойг угтаж үнэ төлбөргүй хандивлаж сүрэг бүрдүүлж байгаа, 8,000.0 мянган төгрөгийн 18 хуцыг шүлхий өвчний нөхцөл байдлаас болоод Дорнод аймагт нийлүүлэгч байгууллагын мал сүрэгт өвөлжүүлж байгаа” гэсэн тайлбар бичгээр ирүүлсэн байна.

2021 оны 03 дугаар сарын 25-ны өдөр зэрлэг ан амьтны тархацтай нутаг болох Хар чулуут, Хонинчулуут, Шарга овоо, Баянсайхан гэх газруудад 340.0 мянган төгрөгийн 1тн өвс, 100.0 мянган төгрөгийн 100кг тэжээл тавьж өгч, 60.0 мянган төгрөгийн шатахууныг зарцуулж биотехникийн арга хэмжээ зохион байгуулсан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 128 мэдээлэл байршуулж, 21 мэдээлэл хугацаа хоцроож 93.0 хувьтай хэрэгжүүлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 2 актын төлбөрийг барагдуулж, өгсөн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 6 дугаар сарын 15-ны 02/80 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарах асуудлыг доорх байдлаар тодорхойлж байна. Үүнд:

1. Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулсан байдал

2. Аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу хувьчлагдсан болон худалдсан хөрөнгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдал

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 246,527.8 мянган төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 164,120.3 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 45,336.3 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 7,349.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 29,722.1 мянган төгрөгийн материаллаг бус 3 зөрчилд зөвлөмж өгөв.

4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн 11,076.6 мянган төгрөгөөр тохируулаагүй алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” - ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “оршин байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Санхүүгийн тайланд улс, орон нутгийн төсвөөс санхүүжигдсэн 76,968.7 мянган төгрөгийн ЗДТГ-ын барилгын дээвэр, 60,000.0 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн, нийт 136,968.7 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгаагүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “оршин байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Аймгийн ОБГ-с авсан хүнсний болон витаминий багц 1,075.0 мянган төгрөг, ОНХСангаас 30 хуц 15,000.0 мянган төгрөгөөр бэлтгэгдсэнийг орлогоор хүлээн зөвшөөрч бүртгээгүй алдаа байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх” заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “тохиолдсон байх”, “оршин байх”, “толилуулга” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн

санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.2 Төлбөрийн акт

Төрийн албаны Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 135 тоот албан бичгээр өгсөн саналыг үндэслэн, удирдах 6 ажилтанд үндсэн цалинг 1.5-1.7 дахин өсгөж 6,982.9 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн сангаас олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилалыг ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 “Урамшуулал гэдэгт ...нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

Нийгмийн даатгалын улсын байцаагчийн 2021 оны 9 дүгээр сарын 14-ний 22 тоот актаар тухайн иргэдэд олгосон орлогоос суутгах нийгмийн даатгалын шимтгэл болон, нийгмийн даатгалын шимтгэлийн алданги, ажил олгогчоос төлөх шимтгэлд нийт 366.2 мянган төгрөгийг төсвөөс төлсөн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “бодитой оршин байх ба тодорхойлогдсон байх” батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

4.3 Албан шаардлага

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр 45,336.3 мянган төгрөгийн хөрөнгө 4 байгууллагаас худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “ Нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг”, гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Худалдан авалттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Худалдан авалтыг е баримтаар баталгаажуулсан байдалд тулгалт хийхэд, 8 байгууллагатай холбоотой 19,722.1 мянган төгрөгийн гүйлгээг баримтжуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", " эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрэн бүрдүүлж байх.

2. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Үндсэн цалинд 136.679.5 мянган төгрөг зарцуулаад 146.679.5 мянган төгрөгөөр и-хуулгын хэлбэлзэл, зардлын тайланд зөрүүтэй тусгасан зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д “төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 37 дугаар зүйлийн 37.1.5-д “төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн

тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төрийн сангийн мэргэжилтний чадавхыг сайжруулж, төсвийн гүйлгээг цахим системээр хэрэгжүүлж хяналт тавих чиг үүргийг хангуулах

3. Нийцлийн аудиттай холбоотой асуудал

3.1.Илрүүлэлт:

Шилэн дансны цахим хуудсанд хугацаа хоцроосон 21 мэдээлэл байна. Хэрэгжилт 93.0 хувьтай байгаа зөрчил байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасантай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3.2.Өгсөн зөвлөмж:

Үнэн зөв, бодитой, ойлгомжтой, иж бүрэн мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар	9	246,527.8	3	164,120.3	2	7,349.1	1	45,336.3	3	29,722.1